

амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт ихээхэн өртөмтгий хvн ам шигvн суурьшсан Ази, Зvн Азийн орнуудад дэлгэрч орон нутгийн иргэд гамшгийн эрсдэлийг бууруулахад бие биедээ харилцан туслалцаа vзvлэх, тухайн орон нутгийн гамшгийн нvхцvл байдал, болзошгvй гамшгийн эрсдэлийн талаар мэдлэг, чадвартай болох, уур амьсгалын өөрчлөлтийн нvлvллvс vдэлтэй гамшигт vзгдлийг хохирол багатай даван туулахын тулд дасан зохицох олон талт ажлыг санаачлан хэрэгжvлж байна.

Мянганы хvгжлийн зорилтод суурилсан vндэсний хvгжлийн цогц бодлоготой уялдуулан Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор ‘Гамшгаас хамгаалах талаар тvрvс баримтлах бодлого, хvтvлбvр’ батлагдаж хvтvлбvрийн 1.9. дэх хэсэгт ‘хvгжлийн бэрхшээлтэй иргэд, хvхэд, vндvр настан зэрэг нийгмийн эмзэг бvлгийн хэрэгцээ шаардлагыг хангасан бэлэн байдлын тусгай хvтvлбvрийг боловсруулж, хэрэгжvлэх’-ээр тусгасан¹. Vнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор ‘Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах vндэсний хvтvлбvр’-ийг баталж 2016-2025 онд хэрэгжvлэхээр ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангахын тулд хvн амын сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулдаг. Иймд гамшгаас хамгаалах мэдлэгийг хvгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох удирдлага, зохион байгуулалтын талаар судлах vй ёсны шаардлага харагдаж байна.

Хvгжлийн бэрхшээлтэй хvмvс тэр дундаа сонсгол, харааны бэрхшээлтэй хvнд явуулж ирсэн сургалтын уламжлал, шинэчлэлд дvн шинжилгээ хийхэд тусгай сургалт нь тvхэн хvгжлийн vе шатуудыг дамжин хvгжиж, манай оронд 2000 оноос интеграчилсан сургалтын vзэл санаа тэгш оролцоог хангах сургалтын шинэ шатанд явагдаж байна.

Хvгжлийн бэрхшээлтэй хvний амьд явах, сурч боловсрох эрхийг тодорхойлсон Хvний эрхийн билль, Хvхдийн эрхийн тухай конвенц, Оюуны хомсдолтой хvний эрхийн тухай тунхаглал, Хvгжлийн бэрхшээлтэй хvний эрхийн тунхаглал, Харааны болон сонсголын бэрхшээлтэй хvний эрхийн тунхаглал, Хvгжлийн бэрхшээлтэй хvмvст тэгш боломж олгох стандарт дvрмvд, Хvгжлийн бэрхшээлтэй хvний эрхийн талаарх Бээжингийн тунхаглал, Монгол Улсын vндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Боловсролын тухай хууль, Хvгжлийн бэрхшээлтэй хvний эрхийн тухай хууль, УИХ-аас баталсан “Тvрvс боловсролын талаар

¹ Гамшгаас хамгаалах талаар тvрvс баримтлах бодлого. - УБ., 2011. УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоолын хавсралт.

баримтлах бодлого” зэрэг асар олон хууль, эрх зүйн актуудыг гаргаж, дагаж мөрдөх, засгийн газрын бодлогын хүрээнд дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна.

БШУС-ын 2014 оны 9 дүгээр сарын 6-ны Үдрийн А/358 дугаар тушаалд "Гамшгаас хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн дагуу оюутнуудад гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг сургалтын төлөвлөгөөнд тусгаж, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн багш нараар заалгаж байхыг төрийн ба төрийн бус эмчийн их, дээд сургууль, коллежийн захирлуудад даалгасан байна.

Манай улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын АНДБЭЗНК-ын (Ази болон Номхон Далайн бүсийг хариуцсан Эдийн засаг, Нийгмийн Комисс) гишүүн ба Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан "Эрхийг нь бодит болгоё" Инчоны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгвэл стратегийн зорилтыг хэрэгжүүлж аюулт үзэгдэл, осолд өртсөн, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хамрагдсан, оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн найдвартай, харьцуулж болох тоо баримтыг тодорхой болгох, хяналтыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдлийг бууруулах, удирдах явдлыг баталгаажуулах зүй ёсны шаардлага харагдаж байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан Гамшгаас хамгаалах талаар төрөөс бодлого, хүтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2013-2014 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагыг хангасан бэлэн байдлын тусгай хүтөлбөрийг боловсруулах” гэсэн арга хэмжээ тусгагдсан боловч хэрэгжээгүй. Иймээс Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хүтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар баталжээ. Энэхүү төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 4 арга хэмжээг оруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэр дундаа сонсгол, харааны бэрхшээлтэй хүнд явуулж ирсэн сургалтын уламжлал, шинэчлэлийг судлахад тусгай сургалт нь төхөөрхөн хөгжлийн төе шатуудыг дамжин хөгжиж, манай оронд интегратчилсан сургалтын үзэл санаа тэгш оролцоог хангах сургалтын шинэ шатанд явагдаж байна.

Монгол Улсад жилд дунджаар (2000-2015 он) 3200 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, 180 гаруй хүн амь насаа алдаж, 89.0 тэрбум

түргэний хохирол учраад байна. Харин аюулт эзгдэл, ослын улмаас хэдэн хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Үртж нас барсан. гамшгаас хамгаалах сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн хамрагдсан судалгаа нийтийн байдлаар хараахан хийгдээгүй байна. Иймд найдвартай, харьдуулж болох хөгжлийн бэрхшээлийн тоо баримтыг сайжруулах шаардлага гарч байна.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан Гамшгаас хамгаалах талаар түрээс баримтлах бодлогын ндсэн чиглэл, мөн тогтоолоор батлагдсан Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх ндэсний хтүлбүрт "хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүхэд, ндүр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагыг хангасан бэлэн байдлын тусгай хтүлбүрийг боловсруулж, хэрэгжүүлэх" стратегийн зорилтыг двшүүлжээ.

Энэхүү бодлого, хтүлбүрийн хүрээнд 2016-2025 онд хэрэгжих “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах ндэсний хтүлбүр”-ийг боловсруулан Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлуулж, ‘Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах’ 2 дугаар зорилтын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг олон нийтэд олгох, эрсдэлгүй зан йлийг хэвшүүлэх, сургалт, сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга барилаар зохион байгуулах, олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ном, гарын авлага, заавар, звлмж сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино, цахим сургалт, гар утасны программ хийх, эзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж нийтэд түгээх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд заагдсан олон эрх амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй, сургалтын үйл явц сайнгүй байгаагийн ндсэн шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын онцлогыг судалж, сурах орчинг бүрдүүлж үүргүй тэдэнтэй ажиллах багш нарыг бэлтгээгүй, ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дутуу чадвартай, тусгай хэрэгцээ шаардлагатай хүмүүс гэсэн буруу ойлголт хандлагаас үүдэлтэй гэж дүгнэж болох юм.